

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2024.02.22	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор: С.Цэвээнсүрэн Утас: 99441515 Цахим хаяг: Tseveensurens@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

МАМ. 02. 23 № 2/23

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

5020119

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 23 ажлыг тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Эрүүл мэндийн газрын зөвлөлөөр хэлэлцүүлж 90.0 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	249,972,578.34	137,434,448.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	85,972,668.58	1,347,723.37
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	85,972,668.58	1,347,723.37
3121	Төгрөг	85,972,668.58	1,347,723.37
31211	Төрийн сангийн харилцах	85,972,668.58	1,347,723.37
33	АВЛАГА	00.00	2,663,620.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	2,663,620.00
34	УРЬДЧИЛГАА	150,000.00	00.00
3471	Урьдчилгаа тооцоо	150,000.00	00.00
34713	Цалингийн урьдчилгаа	150,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	163,849,909.76	133,423,104.93
351	Түүхий эд материал	110,190,825.51	83,596,831.84
35110	Тусгай зориулалттай материал	58,344,914.31	49,144,845.43
35130	Эм боох материал	51,845,911.20	34,451,986.41
354	Хангамжийн материал	53,659,084.25	49,826,273.09
35410	Бичиг хэргийн материал	2,182,000.00	1,609,100.00
35420	Аж ахуйн материал	31,127,250.00	28,587,900.00
35440	Түлш, шатах тослох материал	611,453.25	557,627.09
35450	Барилгын засварын материал	17,211,896.00	18,956,896.00
35460	Хүнсний материал	2,526,485.00	114,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	626,843,310.86	681,772,310.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	626,843,310.86	681,772,310.39
392	Биет хөрөнгө	608,503,310.86	663,432,310.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	453,756,058.00	453,756,058.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-36,416,163.84	-45,918,822.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	46,450,000.00	115,665,625.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,487,222.40	-38,978,658.90
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	225,421,058.31	210,493,392.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-76,640,323.87	-74,958,931.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,992,517.00	56,390,245.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,451,679.20	-14,582,039.52
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,938,000.00	12,938,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,428,933.14	-11,742,557.91
39217	Ном	370,000.00	370,000.00
393	Биет бус хөрөнгө	18,340,000.00	18,340,000.00
39301	Програм хангамж	650,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-650,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	18,340,000.00	18,340,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	876,815,889.20	819,206,758.69
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	187,842.20	6,655,280.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	187,842.20	6,655,280.00
413	Өглөг	187,842.20	6,655,280.00
4136	Бусад өглөг	187,842.20	6,655,280.00
41361	Байгууллагад төлөх өглөг	187,842.20	6,655,280.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	876,628,047.00	812,551,478.69

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо	876,628,047.00	812,551,478.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	580,017,310.00	580,017,310.00
51101	Өмч: - төрийн	580,017,310.00	580,017,310.00
512	Хуримтлагдсан үр дүн	227,692,127.45	163,615,559.14
51210	Өмнөх үеийн үр дүн	227,692,127.45	227,692,127.45
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-64,076,568.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	68,918,609.55	68,918,609.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	876,815,889.20	819,206,758.69

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	736,238,342.16	647,241,829.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	60,195,958.16	102,835,024.06
120	Нийтлэг татварын бус орлого	60,195,958.16	102,835,024.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	644,689,758.35	102,835,024.06
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,846,214.00	70,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	539,701,243.40	100,305,503.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	99,142,300.95	2,459,520.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	676,042,384.00	544,406,805.91
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-55,523,457.29	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-55,523,457.29	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,084,000.00	33,767,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,084,000.00	33,767,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	703,481,841.29	510,639,805.91
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	703,481,841.29	510,639,805.91
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	657,003,767.84	711,318,398.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	657,003,767.84	711,318,398.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	651,399,149.84	709,653,920.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	338,252,135.75	390,849,848.38
210101	Үндсэн цалин	220,589,590.75	273,515,094.03
210102	Нэмэгдэл	71,661,807.40	87,184,468.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,105,805.60	5,397,000.00
210104	Урамшуулал	41,894,932.00	24,753,286.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,334,724.66	48,233,717.54
210201	Тэтгэврийн даатгал	29,580,826.40	32,975,135.02
210202	Тэтгэмжийн даатгал	3,447,568.97	3,793,380.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,727,815.10	3,477,277.52
210204	Ажилгүйдлийн даатгал	599,481.87	726,174.46
210205	Эрүүл мэндийн даатгал	5,979,032.32	7,261,749.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,640,781.00	32,065,022.45

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	3,217,826.00	3,970,322.45
210302	Түлш, халаалт	23,260,830.00	27,913,200.00
210303	Цэвэр, бохир ус	162,125.00	181,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,132,986.91	74,501,953.74
210401	Бичиг хэрэг	4,485,100.00	3,375,200.00
210402	Тээвэр, шатахуун	24,274,438.51	28,391,326.16
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,401,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	162,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,909,050.00	6,006,101.00
210408	Бараа материал акталсны зардал	977,598.40	35,165,126.58
2105	Нормативт зардал	127,759,170.48	81,515,174.65
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	111,677,480.48	65,167,969.65
210502	Хоол, хүнс	16,081,690.00	16,347,205.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,251,040.00	12,564,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	700,000.00	6,419,900.00
210604	Урсгал засвар	6,551,040.00	6,144,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,613,500.00	6,780,000.00
210702	Дотоод албан томилолт	1,613,500.00	6,780,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,787,016.00	1,938,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,032,266.00	1,487,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	335,500.00	451,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,627,795.04	61,205,203.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,622,000.00	4,776,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,005,795.04	56,428,503.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,604,618.00	1,664,477.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,388,214.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,388,214.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,216,404.00	1,664,477.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,216,404.00	1,664,477.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>79,234,574.32</u>	<u>-64,076,568.31</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	148,437.50	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	148,437.50	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-148,437.50	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>79,086,136.82</u>	<u>-64,076,568.31</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>986,760,384.00</u>	<u>541,813,185.91</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	70,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	70,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	70,000.00

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	986,760,384.00	541,743,185.91
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	255,194,542.71	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	255,194,542.71	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,084,000.00	33,767,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,084,000.00	33,767,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	703,481,841.29	507,976,185.91
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	703,481,841.29	507,976,185.91
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	771,491,415.42	615,386,131.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	771,491,415.42	615,386,131.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	765,886,797.42	613,721,653.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,886,721.76	379,913,771.22
210101	Үндсэн цалин	220,044,780.32	261,626,637.44
210102	Нэмэгдэл	70,902,824.94	89,469,281.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,015,804.50	5,017,999.65
210104	Урамшуулал	41,923,312.00	23,799,852.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,726,350.95	59,019,794.70
210201	Тэтгэврийн даатгал	30,849,292.52	40,132,994.70
210202	Тэтгэмжийн даатгал	3,326,581.61	4,721,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,654,585.32	3,777,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	626,053.19	944,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,269,838.31	9,443,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,644,156.00	32,102,522.45
210301	Гэрэл, цахилгаан	3,217,826.00	3,970,322.45
210302	Түлш, халаалт	23,260,830.00	27,913,200.00
210303	Цэвэр, бохир ус	165,500.00	219,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,138,730.00	38,677,900.00
210401	Бичиг хэрэг	5,227,500.00	3,250,200.00
210402	Тээвэр, шатахуун	23,759,730.00	27,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,768,600.00	1,025,200.00
210404	Ном, хэвлэл	20,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	662,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,182,900.00	6,540,500.00
2105	Нормативт зардал	88,029,410.00	71,375,465.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	64,186,160.00	52,479,995.20
210502	Хоол, хүнс	17,078,250.00	13,935,470.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,765,000.00	4,960,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,461,736.00	19,939,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,449,800.00	6,365,900.00
210602	Тавилга	00.00	24,000.00
210604	Урсгал засвар	23,011,936.00	13,549,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,613,500.00	6,780,000.00
210702	Дотоод албан томилолт	1,613,500.00	6,780,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	204,095,792.71	1,146,600.00

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	202,341,042.71	695,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	335,500.00	451,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,290,400.00	4,766,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,290,400.00	4,766,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,604,618.00	1,664,477.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,388,214.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,388,214.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,216,404.00	1,664,477.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,216,404.00	1,664,477.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>215,268,968.58</u>	<u>-73,572,945.21</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	129,296,300.00	11,052,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	129,296,300.00	11,052,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	129,296,300.00	11,052,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	129,296,300.00	11,052,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-129,296,300.00</u>	<u>-11,052,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	85,972,668.58	-84,624,945.21
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	85,972,668.58
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	85,972,668.58	1,347,723.37

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	561,677,310.00	59,739,971.00	-70,918,791.85	00.00	550,498,489.15
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	561,677,310.00	59,739,971.00	-70,918,791.85	00.00	550,498,489.15
4	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-40,805,775.91	00.00	-40,805,775.91
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	580,017,310.00	68,918,609.55	227,692,127.45	00.00	876,628,047.00
6	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	580,017,310.00	68,918,609.55	227,692,127.45	00.00	876,628,047.00
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	580,017,310.00	68,918,609.55	227,692,127.45	00.00	876,628,047.00
8	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-64,076,568.31	00.00	-64,076,568.31
9	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	580,017,310.00	68,918,609.55	163,615,559.14	00.00	812,551,478.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		85,972,668.58		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	774,441,868.58	624,773,653.57	149,668,215.01	80.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	774,441,868.58	624,773,653.57	149,668,215.01	80.67

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	774,441,868.58	624,773,653.57	149,668,215.01	80.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471,267,700.00	379,913,771.22	91,353,928.78	80.62
210101	Үндсэн цалин	279,882,200.00	261,626,637.44	18,255,562.56	93.48
210102	Нэмэгдэл	139,612,800.00	89,469,281.45	50,143,518.55	64.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,148,000.00	5,017,999.65	130,000.35	97.47
210104	Урамшуулал	46,624,700.00	23,799,852.68	22,824,847.32	51.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,019,800.00	59,019,794.70	05.30	100.00
210201	Тэтгэврийн даатгал	40,133,000.00	40,132,994.70	05.30	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,721,700.00	4,721,700.00	00.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,777,500.00	3,777,500.00	00.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	944,200.00	944,200.00	00.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,443,400.00	9,443,400.00	00.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,267,000.00	32,102,522.45	1,164,477.55	96.50
210301	Гэрэл, цахилгаан	4,153,800.00	3,680,221.45	473,578.55	88.60
210302	Түлш, халаалт	27,913,200.00	28,203,301.00	-290,101.00	101.04
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	219,000.00	981,000.00	18.25
2104	Хангамж, бараа материалын зардал	43,367,900.00	38,677,900.00	4,690,000.00	89.19
210401	Бичиг хэрэг	5,447,600.00	3,250,200.00	2,197,400.00	59.66
210402	Тээвэр, шатахуун	25,283,000.00	27,200,000.00	-1,917,000.00	107.58
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,512,000.00	1,025,200.00	1,486,800.00	40.81
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,750,300.00	662,000.00	3,088,300.00	17.65
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,375,000.00	6,540,500.00	-165,500.00	102.60
2105	Нормативт зардал	82,240,700.00	71,375,465.20	10,865,234.80	86.79
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,601,200.00	52,479,995.20	121,204.80	99.77
210502	Хоол, хүнс	22,219,500.00	13,935,470.00	8,284,030.00	62.72
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,420,000.00	4,960,000.00	2,460,000.00	66.85
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,100,000.00	30,991,000.00	27,109,000.00	53.34
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,000,000.00	7,960,900.00	6,039,100.00	56.86
210602	Тавилга	18,000,000.00	5,290,000.00	12,710,000.00	29.39
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	00.00	3,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	23,100,000.00	17,740,100.00	5,359,900.00	76.80
2107	Томилолт, зочны зардал	8,290,068.58	6,780,000.00	1,510,068.58	81.78
210702	Дотоод албан томилолт	8,290,068.58	6,780,000.00	1,510,068.58	81.78
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,050,000.00	1,146,600.00	1,903,400.00	37.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	695,600.00	304,400.00	69.56
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,050,000.00	451,000.00	1,599,000.00	22.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15838700.00	4766600.00	11,072,100.00	30.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,838,700.00	4,766,600.00	11,072,100.00	30.09

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	770,308,268.58	540,148,708.36	230,159,560.22	70.12
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,767,000.00	32,102,522.45	1,664,477.55	95.07
132001	Орон нутгийн төсвөөс	33,767,000.00	32,102,522.45	1,664,477.55	95.07
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	650,568,600.00	507,976,185.91	142,592,414.09	78.08
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	650,568,600.00	507,976,185.91	142,592,414.09	78.08
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	85,972,668.58	70,000.00	85,902,668.58	00.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	70,000.00	-70,000.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	85,972,668.58	00.00	85,972,668.58	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	85,972,668.58	-85,972,668.58	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	1,347,723.37	-1,347,723.37	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	26	-01.00	104.00
620001	Удирдах ажилтан	1	1	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	8	9	-01.00	112.50
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29	28	01.00	96.55
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	16	16	00.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	00.00	100.00
650010	Гэрээт ажилтан	4	3	01.00	75.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	0	0	00.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн зорилго, үйл ажиллагааны чиглэлийг Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар “Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх анхан шатны тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, итгэл найдварт нийцүүлэн чанар, хүртээмжтэй үзүүлэх” гэж зорилго зорилтыг тодорхойлжээ.

2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 23 ажлыг тусган, хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд хэрэгжилт 90 хувьтай байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Г.Сүхбаатар, 2 дугаар гарын үсгийг 1-7 дугаар сард нягтлан бодогч Б.Өлзиймаа, 8-12 дугаар сард Б.Өнөртуяа нар зурсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиудад нийцүүлэн гарсан тогтоол, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Мөн Төсвийн тухай, Төрийн албаны тухай, НББ-ийн тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай хуулиудыг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2021 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	249,972.6	137,434.4	(112,538.1)
Мөнгөн хөрөнгө	85,972.7	1,347.7	(84,624.9)
Авлага	-	2,663.6	2,663.6
Урьдчилгаа	150.0	-	(150.0)
Бараа материал	163,849.9	133,423.1	(30,426.8)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	626,843.3	681,772.3	54,929.0
Үндсэн хөрөнгө	800,917.6	868,403.3	67,485.7
Хуримтлагдсан элэгдэл	(174,074.3)	(186,631.0)	(12,556.7)
Нийт хөрөнгө	876,815.9	819,206.8	(57,609.1)
Өр төлбөр	187.8	6,655.3	6,467.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	876,628.0	812,551.5	(64,076.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	876,815.9	819,206.8	(57,609.1)

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57.609.1 мянган төгрөг буюу 7.7 хувиар буурсан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1.347.7 мянган төгрөг байгаа нь ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын санхүү, даатгалын хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна. Мөнгөн хөрөнгө өмнөх оноос 84.624.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 541.813.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 624.773.7 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд өмнөх оны үлдэгдлээс 84.624.9 мянган төгрөгийг тайлант оны урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн байна.

Авлагын дансны үлдэгдэл 2.663.6 мянган төгрөг нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, тусгасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 133.423.1 мянган төгрөг болж 30.426.8 мянган төгрөгөөр буурч байна.

Төсвийн худалдан авалтаар 137.181.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газраас 2.460.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын болон эм боох материал үнэ төлбөргүйгээр авсан бөгөөд 134.902.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна. Мөн тайлант онд 35.165.1 мянган төгрөгийн бараа материал акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 868.403.3 мянган төгрөг болж 67.485.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 11.052.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 604 тоот тогтоолоор Мэргэжлийн хяналтын газраас 73.000.0 мянган төгрөгийн пургон автомашин балансаас балансад шилжүүлэн авсан, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 107 дугаар захирамжаар 2.855.6 мянган төгрөгийн 1 ширхэг мотоцикл, Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 5/86 тоот албан бичгээр 17.333.3 мянган төгрөгийн гематологийн аппарат, Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/104 тоот тушаалаар 7.116.5 мянган төгрөгийн цахилгааны нөөц батерей тус тус үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 6.655.3 мянган төгрөг байгаа нь тайлант онд үүссэн эм, боох материалын өглөг 4.751.3 мянган төгрөг, шатахууны өглөг 1.100.0 мянган төгрөгөөр үүссэн байна. Энэ нь 2023 оны 11, 12 дугаар саруудад тус сумд томуу, томуу төст өвчлөл их гарсан учир эмийн татан авалт нэмж хийх зайлшгүй шаардлага гарснаас эмийн өглөг үүссэн байна. Мөн эрүүл мэндийн даатгалын сангаас 2.663.6 мянган төгрөгийн авлагатай байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 812.551.5 мянган төгрөг болж 64.076.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 64.076.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжих эх үүсвэрийг 1.067.373.0 мянган төгрөгөөр, орон нутгаас санхүүжих эх үүсвэрийг 42.860.3 мянган төгрөгөөр, нийт 1.110.233.3 төгрөгөөр төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас 335.792.3 мянган төгрөгөөр бууруулж, 774.441.0 төгрөгөөр баталсан байна.

Тайлант хугацаанд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой анх батлагдсан төсөвт 2 удаа өөрчлөлт оруулжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр 507.976.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 33.767.0 мянган төгрөгийн, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 70.0 мянган төгрөгийн, нийт 541.813.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 624.773.7 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 84.624.9 мянган төгрөгийг тайлант оны урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Дд	Хөтөлбөр, арга хэмжээ	Зарцуулах эрх	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	778,982,100.00	624,773,653.57	154,208,446.43	80.20
2	80112 Нийтлэг үйлчилгээ	33,267,000.00	32,102,522.45	1,164,477.55	96.50
3	80302 Нэг иргэнд ногдох нормативаар	453,673,100.00	373,899,990.55	79,773,109.45	82.42
4	81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	206,069,400.00	159,223,327.57	46,846,072.43	77.27
5	83603 Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	85,972,600.00	59,547,813.00	26,424,787.00	69.26

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн данс байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд шатахууны зардалд 25.283.0 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 22.219.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, нээлттэй тендер шалгаруулалтаар “НИК” ХХК-тай шатахуун нийлүүлэх гэрээ, “Эвт уран санаа” ХХК-тай хоол, хүнс нийлүүлэх гэрээ байгуулан ажиллажээ.

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 27.913.2 мянга, гэрэл цахилгааны зардалд 4.153.8 мянга, цэвэр бохир усны зардалд 1.200.0 мянган төгрөг

батлагдсанаас “Хөвийн илч” ХХК-тай дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-тай цахилгаанаар хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Цэвээнсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 114 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааны зардлын дүн 488.093.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.321.4 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.857.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь аймгийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн чиглэлийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар зөрчил илрээгүй.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, аудитаар 36.533.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 425.0 төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосон байна. Төлбөрийн акт, албан шаардлагыг бүрэн биелүүлж, хэрэгжилтийг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 64 тоот албан бичгээр Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	425.0	2	425.0	100%
Албан шаардлага	1	36.533.4	1	36.533.4	100%
Зөвлөмж	-	-	-	-	-
Нийт дүн	3	36.958.4	3	36.958.4	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал: Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----